

**“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 04 сарын 27 өдөр

№ 01

Дархан уул аймаг

“Тээвэр дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026.04.27-ны өдрийн 14⁰⁰ цагт “Монгол-Алт” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд 156301 ширхэг саналын эрхтэй 4 хувьцаа эзэмшигч оролцлоо. Хурлын ирц 95.7%-тай байгаа нь компанийн тухай хуулийн шаардлагыг хангаж байх тул хурлыг эхлүүлэв. Хурлын даргаар Ж.Очирсүхийг сонгов.

Хурлын дарга: Хурлын дэгийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал болох:

1. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан
2. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны зардлын төсөв, дарга гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. Ногдол ашиг олгох тухай

Хурлын дотоод журмын дагуу Санхүүгийн тайланг ерөнхий ня-бо Д.Бямбажаргал, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайланг хараат бус гишүүн Д.Чулуун нар танилцуулав.

Хурлын дарга: Эдгээр тайлангуудтай холбоотой асуулт, санал хэлж болно гэв.

Хараат бус гишүүн Д.Чулуун: Компаний санхүүгийн тайлан балансад хөндлөнгийн аудит, хяналт шалгалтын “Далай ван Аудит” ХХК-тай гэрээ байгуулан улирал бүр зөвлөмж авч санхүүгийн тайлан балансаа мэргэжлийн түвшинд гаргаж байгааг тус хороо сайшаан тэмдэглэж байна. Борлуулалтын урьд оныхоос өссөн дүнтэй харагдаж байгаа боловч үйлчилгээний зарим зардлууд өссөн дүнтэй байгаа нь засвар үйлчилгээ, цалингийн зардал, материалын үнэ нэмэгдсэнтэй холбоотой байна. Шатахууны үнэ нэмэгдэж түүнийг дагаад өргөн хэрэглээний бараа материалын үнэ өссөөр байгааг харгалзан компанийн бизнес үйл ажиллагаа, эдийн засагт учирч болох аливаа сөрөг үр дагаваруудыг тооцон ажилаа төлөвлөх нь зүйтэй. Ингээд мөн “Тээвэр Дархан” ХК-ийн М.Оюун захиралтай хамт олон маш хичээл зүтгэл гарган ажиллаж байгаад талархан, сайшааж байна.

Компанийн ерөнхий нягтлан бодогч Бямбажаргал: Санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны үр дүнгийн тайлан болох компаний орлого, зардал, ашиг алдагдлыг харуулсан тайланг хүснэгтээр харуулж, ярьж нэг бүрчлэн танилцуулав. Ногдол ашгийн өглөг нь өөр газар оршин суудаг бидэнтэй харьцдаггүй хувьцаа эзэмшигчид байдаг бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хороо энэ мөнгийг Монголын Хөрөнгийн Биржид төвлөрүүлэх шаардлага тавьдаг боловч, зохих бичиг баримттайгаа ирвэл ногдол ашгийг нь өгөхөд бэлэн байна. Цаашид компанийн орлогыг нэмэгдүүлж, хөрөнгийн ашиглалтыг сайжируулах, компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох ашгийг нэмэгдүүлэх зорилт тавьж ажиллана.

Хувьцаа эзэмшигч Амарсанаа: Манай байгууллага үйлчилгээний компанидаа татвар төлөгчөөр аймагтаа эхний аравт багтдаг уу?

Компанийн ерөнхий нягтлан бодогч Д.Бямбажаргал: Урьд жилүүдэд найдвартай татвар төлөгч гэрчилгээ жил бүр авч байсан. Үйлчилгээний байгууллагууд дотороо багтана гэж бодож байна. Манай компанийн харилцагч болох түрээслэгч, хувиараа бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүд татвар төлж байгаа хувь хэмжээгээрээ их байдаг гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч М.Оюун: Компанийн үйл ажиллагааны үр дүн, тулгамдсан асуудлуудын талаар дурьдаж санал бодлоо солилцов. (Борооны улирал эхэлж

байгаа тул зах талбайн, үүнд махны хэсэгт илүү ус тогтож үерийн асуудал, газар доорх шугам, суваг шуудуу буруу байгаа) тухай удаа дараа аймагруу асуудлыг шийдүүлэх гэж хүсэлт өгдөг. Дархан захын хажууд Сод монголын ШТС байдаг. Тэдний газар доогуур бохирын шугам байдаг, хамтараад ажиллая гэхэд шатахуун аюултай гэдэг ийм асуудал яригдаад шийдэлд хүрдэггүй.

Хувьцаа эзэмшигч Л.Амарсанаа: Дархан сумын засаг дарга Тулгаад даргад хүсэлтээ өгөөд ойлголцох нь илүү зөв байх, арай шийдвэрт хүрэх нь дөхөм гэж би бодож байна.

Хувьцаа эзэмшигч М.Оюун: за тэгье. Мөн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн болон нарийн бичгийн даргын цалин урамшууллыг нэмэхийг санал болгон ТУЗ-ийн даргын цалин сарын 150000 төгрөг, ТУЗ-ийн гишүүд, хараат бус гишүүдийн цалин 130000 төгрөг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин 120000 төгрөг тус тус болгох санал тавьж хувьцаа эзэмшигчид 100 хувь гаргаа өргөн дэмжиж зөвшөөрөв.

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуулт санал бодол юу байна?

Хувьцаа эзэмшигч М.Оюун: Компанийн тухай хуульд заасан журмын дагуу олон нийтэд мэдээлж, хэлэлцэх асуудлуудыг хүргүүлсэн. Хуульд заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдээс нэмэлт санал, гаднаас санал, нэр дэвшүүлэх хүн ирээгүй. Тиймээс хуучин гишүүдээ дахин үргэлжлүүлэн сонгоё гэж ярьсан. Та бүгдэд өөр бодол байна уу? Хувьцаа эзэмшигчид: Байхгүй, Зөвшөөрч байна. Хараат бус гишүүд: Байхгүй.

Хурлын дарга: Ногдол ашигтай холбоотой санал, асуудал байна уу?

Хувьцаа эзэмшигч Оюун: ТУЗ нь хуралдаж ногдол ашиг олгох шийдвэрээ гаргасан. Иймээс нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 500 төгрөгөөр олгоё. Олгох хугацааг 12 сарын 31-ний дотор гэж үзэж байна. Та бүхэн саналаа хэлнэ үү.

Хувьцаа эзэмшигч М.Цолмон: Дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч Л.Амарсанаа: Дэмжиж байна.

Хурлын дарга: Өөр санал хүсэлт байхгүй бол санал хураалтаа явуулъя. Тооллогын комисс саналын хуудсаа хувьцаа эзэмшигчдэд тараана уу. Санал хураалт явагдаж дүнг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга Г.Энхцэцэг танилцуулж, комиссоос гарах тогтоолоо танилцууллаа.

Хурлын дарга: Тооллогын комиссыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас дараах тогтоолуудыг гаргахаар болж байна Та бүхэнд танилцуулъя.

Үүнд:

1. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан,
2. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны зардлын төсөв, дарга гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. Ногдол ашиг олгох тухай

Хурлын дарга: Хувьцаа эзэмшигч та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье. Хурал 16:45 цагт өндөрлөж байна.

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:

Хурлын дарга:

/ Э.Жавхлантөгс /

/ Ж.Очирсүх /